



БАТЛАВ
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ
Ц.БУМАНБУЯН

2021 оны 07 сарын 06-ны өдөр

**“ХҮНИЙ ХӨГЖИЛ ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ” УРИАНЫ ЖИЛИЙН ХҮРЭЭНД
“ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИГЧ БАЙГУУЛЛАГА”,
“ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИГЧ БАГ” ШАЛГАРУУЛАХ УРАЛДААНЫ
УДИРДАМЖ**

НЭГ. ЗОРИЛГО:

Хамт олон, иргэний эрүүл мэндийг дэмжих тодорхой санал, санаачилга, үйл ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллага, засаг захиргааны нэгж /баг/ шалгаруулах, шагнаж урамшуулах, сурталчлан дэлгэрүүлэх замаар иргэдийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, амьдралын зөв хэвшил, дадал төлөвшүүлж, өвчлөл, нас баралтыг бууруулахад оршино.

ХОЁР. ТАЙЛБАР ТОДОРХОЙЛОЛТ:

“Эрүүл мэндийг дэмжигч байгууллага” гэж хамт олон, олон нийтийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх сургалт, сурталчилгааг тогтмол явуулдаг, уриалга, хөдөлгөөн өрнүүлдэг, нийгэмд үйлчлэх, нийгмийн хариуцлагaa хэрэгжүүлсэн байгууллагыг хэлнэ.

“Эрүүл мэндийг дэмжигч баг” гэж иргэдийн халдварт болон халдварт бус өвчлөл, түүнд нөлөөлөх эрсдэлт хүчин зүйлс, орчны нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, дэмжих үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж, үр дүнд хүрсэн засаг захиргааны нэгжийг хэлнэ.

“Дасгал хөдөлгөөнийг хэвшүүлсэн байх” гэж иргэн дасгал, хөдөлгөөн тогтмол хийж хэвшсэн, үр дүн нь гарсан байхыг хэлнэ.

“Архи, тамхигүй” гэж архи, тамхинаас татгалзах хөдөлгөөн өрнүүлж, амжилтад хүрсэн, тодорхой санхүүжилтийг энэ үйл ажиллагаанд зарцуулдаг байхыг хэлнэ.

“Утаат тамхи” гэж үйлдвэрийн болон гар аргаар ороож бэлтгэсэн, татах зориулалттай янжуур, навчин тамхи, дүнсэн болон түүнтэй адилтгах задгай тамхийг хэлнэ.

“Дам тамхидалт” гэж өөрийн хүсэл зоригоос үл хамааран бусдын татсан тамхины утаагаар амьсгалахыг хэлнэ.

“Эрүүл хооллоптыг хэвшүүлсэн байх” гэж эрүүл зохистой хоолны мэдлэг, мэдээлэлтэй, эрүүл хоолны сонголт хийдэг, үр дүн нь гарсан байхыг хэлнэ.

“Эрүүл мэндийн үзлэгийг хэвшүүлсэн байх” гэж жил бүр эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзэгт /8 ба түүнээс дээш төрөл/ хамруулж хэвшсэн, тодорхой санхүүжилтийг энэ үйл ажиллагаанд зарцуулсан, үр дүн нь гарсан байхыг хэлнэ.

“Эрүүл мэндийг дэмжих, хамгаалах орчин бурдүүлсэн байх” гэж гадаад, дотоод орчноос хүний эрүүл мэндэд үзүүлж байгаа нөлөөллийг бууруулах, иргэд,

албан хаагчдын эрүүл, аюулгүй орчинд ажиллах, суралцах нөхцөлийг бүрдүүлж, үр дүнд хүрсэн байхыг хэлнэ.

ГУРАВ. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА:

1. Сум бүр “Эрүүл мэндийг дэмжигч байгууллага”, “Эрүүл мэндийг дэмжигч баг” сум, орон нутагт шалгаруулах ажлын хэсэг, урамшууллын хэмжээг тогтоож шийдвэр гаргаж, батлах
2. Удирдамж, шалгуур үзүүлэлтийг сумын хэмжээнд үйл ажиллагаа эрхэлж буй Төрийн болон ТББ, ААН-үүдэд сурталчлан, таниулах үйл ажиллагааг жилийн турш зохион байгуулах
3. Сум бүр ЭМДБайгууллага-3, ЭМДБаг-1 тус бүр шалгаруулан урамшуулах
4. Сумандаа шалгарсан ЭМДБайгууллага, ЭМДБаг тус бүр 1-ийг аймгийн ажлын хэсэгт материалыг ирүүлэх
5. Сумдаас ирүүлсэн ЭМДБайгууллага, ЭМДБагийн хэрэгжүүлсэн үйл ажиллагааг аймгийн ажлын хэсгийн гишүүд үнэлж, аймгийн ЭМДБайгууллага-3, ЭМДБаг-3 тус бүр шалгаруулан урамшуулах
6. Аймагт шалгарсан ЭМДБайгууллага, ЭМДБагийн үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн байгууллагаар сурталчлах

ДӨРӨВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Дараах шалгуур үзүүлэлтээр шалгаруулах үнэлгээг хийнэ.

1. “Эрүүл мэндийг дэмжигч байгууллага” шалгаруулах нийт 29 шалгуур, 145 онооны үзүүлэлтийг нэгдүгээр хавсралтаар,
2. “Эрүүл мэндийг дэмжигч баг” шалгаруулах нийт 15 шалгуур, 75 онооны үзүүлэлтийг хоёрдугаар хавсралтаар 0-5 оноогоор дүгнэж, оноог хувьд шилжүүлэн хамгийн өндөр үнэлгээтэй байгууллага, засаг захиргааны нэгж /баг/-ийг шалгаруулна.

ТАВ. ШАЛГАРУУЛАХ ҮЙЛ ЯВЦ, ХУГАЦАА

1-р шат: Сумын ажлын хэсэг нь сумандаа байгууллага, багаас шалгуурын дагуу материал 2021 оны 11 сарын 10-ны өдрийн дотор хүлээн авч, шалгаруулж, урамшуулах үйл ажиллагааг зохион байгуулна.

2-р шат: Суманд шалгарсан Эрүүл мэндийг дэмжигч байгууллага, баг тус бүр нэгийг шалгуур бүрээр баримт материал бүрдүүлж 2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор аймгийн ажлын хэсэгт ирүүлнэ.

Ажлын хэсэг нь 2021 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор хуралдаж, үнэлгээг хийн, дүгнэлт гаргаж, Эрүүл мэндийг дэмжигч байгууллага, багийг шалгаруулна.

ЗУРГАА. ШАГНАЛ, УРАМШУУЛАЛ

Аймгийн Засаг даргын 2019 оны А/396 дугаар захирамжаар батлагдсан шагналын жишиг хэмжээг баримтална.

Шилдэг “Эрүүл мэндийг дэмжигч байгууллага”

1-р байр – Батламж, 300 000 төгрөг

2-р байр – Батламж, 200 000 төгрөг
3-р байр – Батламж, 100 000 төгрөг
Шилдэг “Эрүүл мэндийг дэмжиж баэ”
1-р байр – Батламж, 300 000 төгрөг
2-р байр – Батламж, 200 000 төгрөг
3-р байр – Батламж, 100 000 төгрөг

Эрүүл мэндийг дэмжих ажлуудыг санаачлан, нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлж, шалгарсан байгууллага, засаг захиргааны нэгж /баг/-д өргөмжлөл, мөнгөн шагналыг аймгийн Засаг даргын шийдвэрээр олгож, орон нутгийн телевик, сошиал орчинд үйл ажиллагааг аймгийн хэмжээнд сурталчилна.

ДОЛОО. ХҮРЭХ ҮР ДҮН:

- Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжихэд байгууллага, хамт олны оролцоо, нөлөөллийн үйл ажиллагаа нэмэгдэж, ажлын байранд эрүүл мэндийг дэмжсэн орчин бүрдэнэ.
- Иргэдийн халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэг, шинжилгээнд хамрагдах хандлага нэмэгдэж, өвчлөл, нас бааралт буурна.
- Иргэдийн эрүүл мэндийн боловсрол сайжирч, эрүүл мэндээ хамгаалах, урьдчилан сэргийлэх, амьдралын зөв дадал хэвшүүлэхэд нөлөөлнө.

НАЙМ. МАТЕРИАЛ ХҮЛЭЭН АВАХ ГАЗАР

Суманд: Тухайн сумын ажлын хэсэг,

Аймагт: Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс,

Холбоо барих утас: 70272518,

ХЯНАСАН:

ЗДТГ-ЫН НБХ-ИЙН ДАРГА

д.МӨНХЦЭЦЭГ

БОЛОВСРУУЛСАН:

ЭМГ-ЫН НЭМХ-ИЙН ДАРГА

Т.ГУРБАЗАР



БАТПЛАВ
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ
Ц.БУМАНБУЯН

**“ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИГЧ БАЙГУУЛЛАГА”,
“ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИГЧ БАГ” ШАЛГАРУУЛАХ
АЖЛЫН КАЛЕНДАРЧИЛСАН ТӨЛӨВЛӨГӨӨ**

2021.07.26

| № | Хэрэгжүүлэх ажил | Хугацаа | Зохион байгууллах нэгж |
|----|---|------------------------|--------------------------|
| 1 | Удирдамж, шалгуурыг боловсруулж, батлуулах | 7 сард | ЭМГазар |
| 2 | Удирдамж, шалгуурыг сумдад хүргүүлэх | 7 сард | Аймгийн ажлын хэсэг |
| 3 | Шалгуурыг Төрийн байгууллага болон ТББ, ААН-ҮҮДЭД сурталчлах, уриалах, хөдөлгөөн өрнүүлэх | 7-11 сард | Аймаг, сумын ажлын хэсэг |
| 4 | Сумандаа шалгаруулах ажлын хэсэг, шагналын сангаа баталж, шийдвэр гаргах | 7 сард | Сумын ажлын хэсэг |
| 5 | ЭМДБайгууллага, ЭМДБаг бий болгох хөдөлгөөн өрнүүлсэн, хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаар явцын тайлан сумдаас авч, ажлын хэсэгт танилцуулах | 9 сард | ЭМГазар |
| 6 | Сумандаа байгууллага, багаас шалгуурын дагуу материал хүлээн авч, шалгаруулж, урамшуулах үйл ажиллагааг зохион байгуулах | 11 сарын 10-ны дотор | Сумын ажлын хэсэг |
| 7 | Сумаас шалгарсан байгууллага, багийн материалыг аймгийн ажлын хэсэгт ирүүлэх | 11 сарын 15-ны дотор | Сумын ажлын хэсэг |
| 8 | Аймагт ирүүлсэн материалыг дүгнэж, ЭМДБайгууллага, ЭМДБагийг шалгаруулах | 11 сарын 25-ны дотор | Аймгийн ажлын хэсэг |
| 9 | Шалгарсан байгууллага, багт шагнал олгох шийдвэрийн төсөл боловсруулж, батлуулах | 11 сарын 30-ны дотор | Аймгийн ажлын хэсэг |
| 10 | Аймгийн ЭМДБайгууллага, ЭМДБагт шагналыг гардуулах үйл ажиллагааг зохион байгуулах | 12 сард | АЗДТГ, ЭМГ |
| 11 | ЭМДБайгууллага, ЭМДБаг шалгаруулах үйл ажиллагааны тайлан мэдээллийг аймгийн Засаг даргын зөвлөлд танилцуулах | 12 сард | АЗДТГ-ын НБХ, ЭМГ |
| 12 | Аймгийн хэмжээнд шалгарсан байгууллага, багийн үйл ажиллагааг хэвлэл мэдээллээр сурталчлах | 12 сар, 2022 оны 1 сар | АЗДТГ-ын ХМОНХАлба, ЭМГ |


 БАТГАВ
 АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ
 Ц.БУМАНБУЯН

**“ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИГЧ БАЙГУУЛЛАГА” ШАЛГАРУУЛАХ
ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

| | Шалгуур үзүүлэлт | Үнэлгээ өгөх оноо |
|---|---|----------------------|
| 1 | Эрүүл мэндийг дэмжигч байгууллага болох зорилт тавьж бодлого, төлөвлөгөөндөө тусгасан байх | 5,3,1,0 |
| 2 | Байгууллагын төсөвт эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, орчин бүрдүүлэх зэрэг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд санхүүжилт төлөвлөж, хэрэгжүүлсэн бол | 5,3,1,0 |
| 3 | Албан хаагчдын эрүүл мэндийн асуудлыг хариуцсан орон тооны бус ажилтан томилж, жилийн ажлын төлөвлөгөөнд нь тодорхой ажлуудыг тусгасан байх | 5,3,1,0 |
| 4 | Эрүүл мэндийн сургалт, сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээ 12-с доошгүй удаа зохион байгуулж, үр дүнг тооцсон бол | 5,3,1,0 |
| “Дасгал, хөдөлгөөнийг хэвшүүлэх” чиглэлээр | | |
| 5 | Дасгал, хөдөлгөөн хийх ач холбогдлыг таниулсан сургалт, мэдээллийг ажиллагсдад жилд 3-с доошгүй удаа зохион байгуулсан бол | 5,3,1,0 |
| 6 | Ажлын байранд бүх ажиллагсад дасгал хөдөлгөөнийг 3 ба түүнээс дээш сарын хугацаагаар хийж хэвшүүлсэн бол | 5,3,1,0 |
| 7 | Байгууллагын хамт олны биеийн жингийн индекс /БЖИ/-ээ тогтоож, хэвийн хэмжээнд хүргэх үйл ажиллагаа зохион байгуулж, үр дүнг тооцсон бол/ Суурь түвшинг тодорхойлж, хүрэх түвшинтэй харьцуулан үнэлж дүгнэх / | 5,3,1,0 |
| 8 | Таргалалт, илүүдэл жинтэй ажилчдын 2/3 нь биеийн жингийн индексээ хэвийн хэмжээнд ойртуулах шат ахиулсан бол | 5,3,1,0 |
| 9 | Ажилчдын биеийн жингээ хэмжих, БЖИ-ээ хянах орчин бүрдүүлсэн байх | 5,3,1,0 |
| 10 | Байгууллага, хамт олноороо өглөөний дасгал, алхалт хийдэг бол/ Тогтмол дасгал хөдөлгөөн хийдэг албан хаагчдын тоо, ахиц, үр дүнгээр/ | 5,3,1,0 |
| 11 | Байгууллагын ажилчдад зориулсан дасгал хөдөлгөөн хийх өрөө, танхимтай, үйл ажиллагаа тогтмол явуулдаг бол | 5,3,1,0 |
| “Эрүүл хооллолтыг хэвшүүлэх” чиглэлээр | | |
| 12 | Эрүүл хооллолт гэж юу вэ? түүний ач холбогдлыг таниулсан сургалт, мэдээллийг ажиллагсдад жилд 3-с доошгүй удаа зохион байгуулсан, үр дүнг тооцсон байх | 5,3,1,0 |
| 13 | Байгууллагын албан хаагчдын хоногийн давсны хэрэглээг тодорхойлж, давсны хэрэглээг бууруулах чиглэлээр нөлөөллийн ажил зохион байгуулж, үр дүнг тооцсон байх | 5,3,1,0 |
| 14 | Ажлын байранд ажилчдад хүрэлцэхүйч, шаардлага хангасан ундны ус цэвэршүүлэгчээр хангагдсан, шүүлтүүрийг тогтмол сольдог байх | 5,3,1,0 |
| 15 | Ажлын байранд ундны усны эх үүсвэр чанарын шаардлага хангасан, усны чанарыг шинжилгээгээр баталгаажуулдаг байх | 5,3,1,0 |
| “Архи тамхины эсрэг” чиглэлээр | | |
| 16 | Архи, тамхины хортой хэрэглээг таниулсан сургалт, мэдээллийг ажиллагсдад жилд 5-с доошгүй удаа зохион байгуулсан байх | 5,3,1,0 |
| 17 | Архи, тамхины хор уршигийг ойлгуулсан, эрсдэлт зан зүйл, архи тамхинаас гарах зөвлөмжээр ажиллагсдад 5-с доошгүй удаа зохион байгуулсан байх | 5,3,1,0 |

| | | |
|--|--|------------|
| 18 | Архигүй хамт олон болох хөдөлгөөн өрнүүлсэн байх | 5,3,1,0 |
| 29 | Тамхигүй хамт олон болох хөдөлгөөн өрнүүлж, тамхи татдаг ажилчдын 50 дээш хувь нь тамхинаас бүрмөсөн татгалзаж чадсан байх | 5,3,1,0 |
| “Эрүүл мэндийн үзлэгийг хэвшүүлэх” чиглэлээр | | |
| 20 | Байгууллагын ажилчдын эрүүл мэндийн байдал, өвчлөлийн байдлын судалгаатай байх | 5,3,1,0 |
| 21 | Бүх ажилчдыг жил бүр насны бүлгээр урьдчилан сэргийлэх, багцын үзлэг, оношилгоонд хамруулсан байх | 5,3,1,0 |
| 22 | Урьдчилан сэргийлэх үзлэгийн дүнд өвчтэй илэрсэн ажилчдыг эмчилгээнд хамруулж, үр дүнг тооцсон байх | 5,3,1,0 |
| 23 | Ажиллагсад ажлын байрандаа цусны даралтаяа тогтмол хянаж хэмжих орчин бүрдүүлж, даралтны аппарат байршуулсан, тогтмол ашигладаг байх | 5,3,1,0 |
| “Эрүүл мэндийг дэмжих, хамгаалах орчин бүрдүүлэх” чиглэлээр | | |
| 24 | Ажилчдад стресс менежмент, сэтгэл зүйн чиглэлээр 3-д доошгүй удаа сургалт зохион байгуулсан байх | 5,3,1,0 |
| 25 | Алжаал тайлах өрөөтэй, ажилчдад ээлтэй байдлаар тохижуулсан байх | 5,3,1,0 |
| 26 | Ажилчдад ариун цэврийн өрөө, гар угаах орчин нөхцөл хангагдсан, хүрэлцээтэй байх | 5,3,1,0 |
| 27 | Байгууллагад анхны тусламж үйлчилгээ үзүүлэх булан бүхий шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслээр хангасан байх | 5,3,1,0 |
| 28 | Байгууллагын явган хүний зам, шат, ариун цэврийн өрөө нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээнд нийцдэг байх | 5,3,1,0 |
| 29 | Ажлын байранд осол гэмтлээс сэргийлэх, хамгаалах үйл ажиллагааг зохион байгуулдаг, байх | 5,3,1,0 |
| НИЙТ ОНОО | | 145 |

---Оо---



**“ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИГЧ БАГ” ШАЛГАРУУЛАХ
ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

| | Шалгуур үзүүлэлт | Үнэлгээ өгөх оноо |
|------------------|---|------------------------------|
| 1 | “Эрүүл мэндийг дэмжигч баг” болох зорилт тавьж бодлого, төлөвлөгөөндөө тусгасан байх | 5,3,1,0 |
| 2 | Багийн иргэдийн дунд эрүүл мэндийн сургалт, сурталчилгаа, нэлөөллийн арга хэмжээ 10-с доошгүй удаа зохион байгуулж, үр дүнг тооцсон бол | 5,3,1,0 |
| 3 | Багийн иргэдийн биеийн жингийн индекс /БЖИ/-ээ тогтоож, хэвийн хэмжээнд хүргэх үйл ажиллагаа зохион байгуулж, үр дүнг тооцсон бол/БЖИ хэвийн иргэдийн тоо,хувь ахицаар/ | 5,3,1,0 |
| 4 | Багийн иргэд өглөөний дасгал, алхалт хийдэг байх/Тогтмол дасгал хөдөлгөөн хийдэг иргэдийн тоо,ахиц, үр дүнгээр/ | 5,3,1,0 |
| 5 | Эрүүл хооллолт гэж юу вэ? түүний ач холбогдлыг таниулсан сургалт, мэдээллийг иргэдийн дунд жилд 3-с доошгүй удаа зохион байгуулсан, үр дүнг тооцсон байх | 5,3,1,0 |
| 6 | Архи, тамхины хортой хэрэглээг таниулсан сургалт, мэдээллийг жилд 5-с доошгүй удаа зохион байгуулсан байх | 5,3,1,0 |
| 7 | Тамхигүй хамт олон болох хөдөлгөөн өрнүүлж, тамхи татдаг иргэдийн 10 дээш хувь нь тамхинаас бүр мөсөн татгалзаж чадсан байх | 5,3,1,0 |
| 8 | Иргэдэд сэтгэл зүйн чиглэлээр сургалт, нэлөөллийн ажлыг 3-с доошгүй удаа сургалт зохион байгуулсан байх | 5,3,1,0 |
| 9 | Багийн иргэдийн насны ангилал, эрүүл мэндийн байдлын судалгаатай байх | 5,3,1,0 |
| 10 | Багийн иргэдийн дунд халдварт бус өвчлөл, түүнд нэлөөлөх эрсдэлт хүчин зүйлийн судалгаатай байх | 5,3,1,0 |
| 11 | Багийн иргэдийг жил бүр насны бүлгээр урьдчилан сэргийлэх, багцын үзлэг, оношилгоонд хамруулсан байх /УС үзлэгт хамрагдсан иргэдийн тоо, хувь/ | 5,3,1,0 |
| 12 | Урьдчилан сэргийлэх үзлэгийн дунд өвчтэй илэрсэн иргэдийг эмчилгээнд хамруулж, үр дүнг тооцсон байх | 5,3,1,0 |
| 13 | Багийн иргэдийн үндны усыг улирал бүр шинжилгээнд хамруулсан байх | 5,3,1,0 |
| 14 | Сургууль, цэцэрлэг, эмнэлэг, үндны худгийн орчмын хөрсийг жилд 2 удаа шинжилгээнд хамруулсан байх | 5,3,1,0 |
| 15 | Нүхэн жорлон, угаадасны нүхээ сайжруулах нэлөөллийн арга хэмжээ зохион байгуулж, үр дүнг тооцсон байх | 5,3,1,0 |
| НИЙТ ОНОО | | 75 |

---оо---